



ХӨТӨЛИЙН ЦЕМЕНТ ШОХОЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

43131 Сэлэнгэ аймаг, Сайхан сум, Хөтөл баг,
УБД: 9010001106, Утас: 7036-8151, Факс: (976) 7036-8368
И-мэйл: info@khutulcement.mn

2022.03.25 № 01/228
танай _____ -ны № _____ -т

Хариу хүргүүлэх тухай

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАРТ

Юуны түрүүнд Засгийн газрын 2022 оны 124 дүгээр тогтоол, ТӨБЗГ-ын тогтоолыг хэрэгжүүлэх нэрийдлээр ТӨБЗГ-ын дарга Б.Цэнгэлээр ахлуулсан ажлын хэсэг цагдаагийн байгууллагын хүчийн үзүүлж, хүч хэрэглэн Хөтөлийн Цемент Шохой XK-ийн оффисыг булаан авахаар дайрч байгааг эрс эсэргүүцэж байна. Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх” болон Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан “Агентлагийн үйл ажиллагааны зарчим”, 18 дугаар зүйлд заасан “Агентлагийн үйл ажиллагаанд хориглох зүйл” хэсгүүдэд тус тус зааснаар Хувийн хэвшлийн байгууллага, хуулийн этгээд төрийн өмчийн төлөөлөгч, ажлын хэсэгт ажиллах өрөө гаргах, хуулийн этгээдийн байгууллагын хувийн мэдээллийг гаргаж өгөх үүрэг хүлээгээгүй.

Иймд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 03 сарын А-4/527 дугаартай шаардлагыг хүлээж авах боломжгүйг үүгээр мэдэгдэж байгааг хүлээн авна уу. Түүнчлэн “ажлын хэсэг” гэхийг хэрхэн, яаж, ямар бүтэц бүрэлдэхүүн, зорилготой байгуулсныг манай байгууллагад мэдэгдээгүй тул “Төрийн хяналт шалгалтын тухай” хуульд заасан удирдамж чиглэлийг эх хувиар ируулэхийг хүсье.

Тус албан бичигт гарын үсэг зурсан “ажлын хэсгийн ахлагч” гэх Ц.Баяр-Эрдэнэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрыг итгэмжлэлгүйгээр төлөөлөн агентлагийн албан бланк, тамга тэмдгийг ашиглах эрхтэй этгээд мөн эсэхийг тогтоолгон, албаны эрх мэдлээ урвуулан ашигласан байх магадлалтай тул холбогдох хууль, хяналтын байгууллагад гомдол гаргаж шийдвэрлүүлэх болно гэдгийг хариуцлагатайгаар мэдэгдье.

Эцэст нь Хөтөлийн” Цемент Шохой” XK-ийг хувьчлан авсан Хөтөл ХХК-ийн хууль ёсны өв залгамжлагч Бөх-Очирын Тулга нь өөрийн хөрөнгө хүлээн авах, өв нээлгэх хүсэлтээ

2019 оноос хойш хөөцөлдөж байгаа. Гэвч Хөгжлийн банкнаас 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 3/409 тоот албан бичгээр Монголын Нотариатчидын танхим руу “өв нээхгүй байх тухай” мэдэгдэл хүргүүлж, саад учирч байгаа. Хөгжлийн банкнаас дээрх хүсэлтээ цуцалж, өв залгамжлагч Бөх-Очирын Тулгад өвөө хүлээн авах, Хөтөлийн” Цемент Шохой” ХК-ийн 100 хувийн хувьцаа эзэмшигч Хөтөл ХХК-ийн өмчлөгчөөр нэн даруй бүртгүүлэх боломжоор хангасан нөхцөлд бид хуулийн хүрээнд төрийн байгууллагатай хамтран ажиллахад бэлэн байгаагаа мэдэгдэж байна.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



A handwritten signature in black ink, appearing to read "Д.ЧИНБАТ".

Д.ЧИНБАТ



“ЦЕМЕНТ ШОХОЙ” ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Д.ЧИНБАТ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайвны өргөн чөлөө 16, Засгийн газрын IX байр,
Утас/Факс: (976-51) 26 23 50, И-мэйл: info@pcsp.gov.mn,
Вэбсайт: www.pcsp.gov.mn

2022. 03. № A-4 / 527.
таний _____-ны № _____-т

Шаардлага хүргүүлэх тухай

Засгийн газрын 2022 оны 124 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 108 дугаар тогтоолыг хэрэгжүүлж Төрийн өмчийн төлөөлөгч болон ажлын хэсгийн ажиллах нөхцөлийг хангаж ажиллах өрөө, холбогдох мэдээллийг шуурхай гаргаж өгөхийг шаардаж байна.

АЖЛЫН ХЭСГИЙН
АХЛАГЧ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ



Өв хүлээн авахаас татгалзах тухай хүсэлт

2021.03.24

Улаанбаатар хот

Бөх-Очир овогтой Хулан (РД:УХ90083141) би 1990 оны 08 дугаар сарын 31-ний өдөр Бөх-Очир болон Чимгээ нарын анхны хүүхэд болж төрсөн.

Миний аав Базарсад овогтой Мижидийн Бөх-Очир (РД:ХИ67042775) нь 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр нас барсан. Улмаар Иргэний Бүртгэл Мэдээллийн төвөөс 2018 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр 0000219996 дугаартай нас барсны гэрчилгээ олгогдсоноор өв нээгдсэн.

Иргэний хуулийн 528 дугаар зүйлийн 528.5 дахь хэсэгт заасныг үндэслэн хууль ёсны өмчлөгч нь болох Базарсад овогтой Бөх-Очирын Хулан (РД:УХ90083141) би “Хөтөл” ХХК-ийн нэг бүр нь 1,000 (нэг мянга) төгрөгийн үнэтэй, нийт 200,000 (хоёр зуун мянга) ширхэг энгийн эрхийн хувьцаа буюу гаргасан 100 хувийн хувьцааг өвлөх эрхээсээ Иргэний хуулийн 528 дугаар зүйлийн 528.5 дахь хэсэгт зааснаар татгалзаж байна.

Бид гэр бүлээрээ хэлэлцээд дээрх өв хөрөнгийг Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, 7-р хэсэг, Маршал таун, Олимп гудамж, 110-р байр, 3 тоотод оршин суух хаягтай миний дүү болох Бөх-Очир овогтой Тулга (РД:УХ92051994)-д өвлүүлэхээр шийдвэрлэсэн.

Иймд, өвлөх эрхийн гэрчилгээг миний дүү Бөх-Очир овогтой Тулга (РД:УХ92051994)-д олгож өгнө үү.

Хүсэлт гаргасан Хулан
Б.Хулан

Регистрийн дугаар: УХ90083141

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7-р хороо, 11-р хороолол, Эрхүүгийн гудамж, 10в байр, 8 тоот;

Утас: 91916782



2021.03.24 одор Бүртгэлийн № 167...

Нийтийн Сүхбаатар дүүрэгийн
төгрөгийн потариатыг Ч.Баянжаргал би,
энэ гарын үсгийн үзүүлэвийн гарынай.
Үйлчилгээний хонсонд Л.О. төслийн хуралдаан
Потариатыг З.С.

Өв хүлээн авахаас татгалзах тухай хүсэлт

2021.03.24

Улаанбаатар хот

Миний нөхөр болох Базарсад овогтой Мижидийн Бөх-Очир (РД:ХИ67042775) нь 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр нас барсан. Улмаар Иргэний Бүртгэл Мэдээллийн төвөөс 2018 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр 0000219996 дугаартай нас барсны гэрчилгээ олгогдсоноор өв нээгдсэн.

Иргэний хуулийн 528 дугаар зүйлийн 528.5 дахь хэсэгт заасныг үндэслэн хууль ёсны өмчлөгч нь болох Хас овогтой Чулуунбаатарын Чимэг (РД:ХИ69012987), хүү Бөх-Очирин Төгөлдөр (РД:УХ04291431) бид “Хөтөл” ХХК-ийн нэг бүр нь 1,000 (нэг мянга) төгрөгийн үнэтэй, нийт 200,000 (хоёр зуун мянга) ширхэг энгийн эрхийн хувьцаа буюу гаргасан 100 хувийн хувьцааг өвлөх эрхээсээ Иргэний хуулийн 528 дугаар зүйлийн 528.5 дахь хэсэгт зааснаар татгалзаж байна.

Дээрх өв хөрөнгийг Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, 7-р хэсэг, Маршал таун, Олимп гудамж, 110-р байр, 3 тоотод оршин суух хаягтай миний хүү болох Бөх-Очир овогтой Тулга (РД:УХ92051994)-д өвлүүлэхийг зөвшөөрч байна.

Компанийн Гүйцэтгэх захирлыг томилж хуулийн этгээдийн холбогдох хууль болон Төрийн эрх бүхий байгууллага, банкны өмнө хүлээсэн үүргийг биелүүлэх асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгаа.

Иймд, өвлөх эрхийн гэрчилгээг миний хүү Бөх-Очир овогтой Тулга (РД:УХ92051994)-д олгож өгнө үү.

Хүсэлт гаргасан Ч.Чимэг
Ч.Чимэг

Хүү Б.Төгөлдөрийг төлөөлж Ч.Чимэг
Ч.Чимэг

Регистрийн дугаар: ХН69012967

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7-р хороо, 11-р хороолол, Эрхүүгийн гудамж, 10в байр, 8 тоот;

Утас: 99107314



2021.03.24 одор Бүрээндэй № 168

Нийтийн Сүхбаатар дүүрэгийн
төгрөгийн нийтийн Ч.Баянгаргай би
энэ гарын үсүүн үзүүлжин дэшиж төрнөв.
Үзүүлжээний хүчиндэд 4.0
Нийтийн Ч.Баянгаргай

Өвлөх эрхийн гэрчилгээ гаргуулах хүсэлт


Бөх-Очир овогтой Тулга (РД:УХ92051994) би 1992 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Бөх-Очир, Чимэг нарын ууган хүү болж төрсөн.

Миний эцэг М.Бөх-Очир нь 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр өвчний улмаас таалал төгссөн. Улмаар, түүний Улсын бүртгэлийн 9011174063 дугаар, Регистрийн 5268052 дугаартай “Хөтөл” ХХК-ийн нэг бүр нь 1,000 (нэг мянга) төгрөгийн үнэтэй, нийт 200,000 (хоёр зуун мянга) ширхэг энгийн эрхийн хувьцаа буюу гаргасан 100 хувийн хувьцааг өвлөж, өвлөх эрхийн гэрчилгээ гаргуулах хүсэлтэй байна..

Бид гэр бүлээрээ хэлэлцэн тохирч “Хөтөл” ХХК-ийн хувьцааг надад өвлүүлж, эзэмших эрхийг шилжүүлэхээр шийдвэрлэсэн. Тодруулбал, миний эгч Б.Хулан (РД:УХ90083141), ээж Ч.Чимэг (РД:ХН69012987), дүү Б.Төгөлдөр (РД:УХ04291431) нар нь хувьцааг өвлөх өвлөх эрхээсээ татгалзаж, үүнийгээ баталгаажуулсан.

Иймд, миний эцэг М.Бөх-Очирын дангаар эзэмшиж байгаа буюу хувьцаа эзэмшигчээр бүртгэлтэй байгаа Улсын бүртгэлийн 9011174063 дугаар, Регистрийн 5268052 дугаартай “Хөтөл” ХХК-ийн нэг бүр нь 1,000 (нэг мянга) төгрөгийн үнэтэй, нийт 200,000 (хоёр зуун мянга) ширхэг энгийн эрхийн хувьцааг өвлөх эрхийн гэрчилгээг олгож өгнө үү.

Холбогдох баримт бичгийг хавсаргав.



Б.Тулга

2021.03.24



МОНГОЛЫН
НОТАРИАТЧЫН ТАНХИМ

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН
БАНКНЫ ТЭРГҮҮН ДЭД
ЗАХИРАЛ Ч ЭНХБАТ ТАНАА

165
156

210620 Гуламбаатар хот Сүхбаатар дүүрэг
Эмчилгэн нийтийн төхөн, 10 талр. НЭС 374301
Фонд: 076-11-104300
Санал Тайлт олон улсын банкны танхимын нийтийн төхөн

2020.03.24 № 175
төслийн дат 03.23 төслийн № 3409



Хариу хүргүүлэх тухай

Танай ирүүлсэн 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 3/409 дүгээр албан бичийн дагуу Хетэл ХХК болон түүний охин компани болох "Цемент шохой" ХХ-тай холбоотойгоор өвлих эрхийн гэрчилгээг олгоходоо өвлөгид Иргзний хуулийн 535 дугаар зүйлд заасан өвлөгийн хариуцлагын талаар албан ёсоор мэдэгдэх, эдгээр компанийн бүтцэд өөрчлөлт оруулах ямарвaa нэгэн гэрээ хэлцэлд банкнавас ирүүлсэн албан тоот мэдэгдлийг үндэслэн гэрчлэх талаарх холбогдох мэдээллийг нийслэл, орон нутгийн нийт нотариатчадад уламжилсан болно.

Жич нотариатын тухай хуульд засны дагуу нотариатч нь нотариатын үйл ажиллагааг Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн вазрын гишүүнээс олгосон зөвшөөрлийн үндсэн дээр бие даван харахад бусаар эрхлэдэг болно.

Хавсралт / хуудастай

Хүндэтгэсэн,
ЕРӨНХИЙ ТЭГС



From : Mongolia Notary <archive@notary.mn>
 Subject : Лавлагааны хариу
 Date : 29-03-2021 9:20
 To : Gombo Badamsuren <badamsuren@notary.mn>;

**НИЙСЛЭЛИЙН ТОЙРГИЙН
НОТАРИАТЧ Г.БАДАМСҮРЭН ТАНАА**

2021.03.29

№760

Улаанбаатар хот

Таны ирүүлсэн хүсэлттэй танилцлаа. 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр нас барсан Мижидийн Бөх-Очир / ХИ67042775/-ын өмчлөлийн "Хөтөл" ХХК-ийн 100% хувьцааг Хас овогт Чулуунбаатарын Чимэг /ХН69012967/, Базарсад овогт Бөх-Очирын Төгөлдер /УХ04291431/ нар өв хүлээн авахаас татгалзсан хүсэлт гаргасны дагуу Сүхбаатар дүүргийн тойргийн нотариатч П.Гэрэлмаа 2019 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр гарын үсгийн 89 дугаарт бүртгэж гэрчилсэн байна. Зээлдэгч "Хөтөл" ХХК (хуучнаар "Бейзмент" ХХК) нь "Монгол Улсын Хөгжлийн банк" ХХК-тай 2012 оны 10 дугаар сарын 16-ны өдөр 3-БМ-Х 2012-147 дугаартай "Зээлийн гэрээ"-г, 2013 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр 3-БМ-Х 2013-203 дугаартай, 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдөр 3-БМ-Х 2012-147-1 дугаартай "Зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээ"-г байгуулан нийт 61,265,000.00 (жаран нэгэн сая хоёр зуун жаран таван мянган) ам.долларын зээлийг 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл жилийн 8.1 (хувь), 2016 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш жилийн 7.85 хувийн хүүтэй, 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдөр хүртэл хугацаатай, "Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилт хөтөлбөр"-ийн хүрээнд Хөтөлийн "Цемент шохой" ХК-ийн "Хөтөлийн цементийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг жилд нэг сая тоннд хүргэх төсөл"-ийг санхүүжүүлэх зориулалтаар авсан. Зээлдэгч "Хөтөл" ХХК-ийн хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал М.Бөх-Очирын банктай байгуулсан зээлийн үлдэгдэл 90,744,498.48 (ерэн сая долоон зуун дөчин дөрвөн мянга дөрвөн зуун ерэн найман ам.доллар, дөчин найман цент) ам.доллар (Монголбанкаас зарласан ханшийн лавлагаа 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн ханш ам.доллар 2,674.62 төгрөг) тооцож нийт 242,707,050,525.00 (хоёр зуун дөчин хоёр тэрбум долоон зуун долоон сая тавин мянга таван зуун хорин таван) төгрөгийн өртэй талаар Монгол Улсын Хөгжлийн банкнаас гомдлын шаардлага гаргасныг Сүхбаатар дүүргийн тойргийн нотариатч Ч.Баянжаргал 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Гарын үсгийн 746 дугаарт бүртгэж гэрчилсэн байна.

"Хөтөл" ХХК-ийн нэг бүр нь 1,000 /нэг мянга/ төгрөгийн үнэтэй, нийт 200,000 /хоёр зуун мянган/ ширхэг энгийн эрхийн хувьцаа буюу гаргасан 100%-ийн хувьцааг тус тус Бөх-Очирын Хулан /УХ90083141/, Чулуунбаатарын Чимэг /ХН69012967/, Бөх-Очирын Төгөлдер /УХ04291431/ нар өв хүлээн авахаас татгалзсан хүсэлт гаргасныг Нийслэлийн тойргийн нотариатч Ч.Баянжаргал 2021 оны 03 сарын 24 өдөр гарын үсгийн 167, 168 дугаарт бүртгэж гэрчилсэн байна. Өвлүүлэгчдийн эд хөрөнгө, эрх өвлөхтэй холбоотой бусад мэдээлэл түүний хууль ёсны өв залгамжлагчдаас өв хүлээн авах, өв хүлээн авахаас татгалзсан хүсэлт гаргасан эсэх, нотариатчаас өвлөх эрхийн гэрчилгээ олгосон эсэхийг танхимын өвийн нэгдсэн бүртгэлээс шүүж үзэхэд бүртгэгдсэн мэдээлэл байхгүй байна.

Дээрх эд хөрөнгө гэрээслэгдсэн эсэхийг 2007 оноос хойши Танхимын гэрээслэлийн нэгдсэн бүртгэлээс шүүж үзэхэд бүртгэгдсэн мэдээлэл олдоогүй болно.

АРХИВЫН АЖИЛТАН Э.МЯГМАРНАРАН